



**“БУЛИГААР” ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

<i>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт I/</i>													
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>													
Тайлагнах хугацаа	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр												
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Булигаар” ХК УБГД: 9010001072 MSE: MBG Утас: 99190037 И-мэйл: info@buligaar.com												
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК												
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Арьс шир боловсруулалт Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа												
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Сэрэлт дөл аудит” ХХК 2019-08-28												
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	400,212,000												
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Г.Оюунгэрэл ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Анхболд												
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан <i>/хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>												
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<table> <tr> <td>Эргэлтийн хөрөнгийн дүн:</td> <td>15,416,088,640.32</td> </tr> <tr> <td>Эргэлтийн бус хөрөнгийн дүн:</td> <td>18,541,300,441.93</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн дүн:</td> <td>33,957,389,082.25</td> </tr> <tr> <td>Өр төлбөрийн нийт дүн:</td> <td>22,294,624,890.31</td> </tr> <tr> <td>Эздийн өмчийн дүн:</td> <td>11,662,764,191.94</td> </tr> <tr> <td>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:</td> <td>33,957,389,082.25</td> </tr> </table>	Эргэлтийн хөрөнгийн дүн:	15,416,088,640.32	Эргэлтийн бус хөрөнгийн дүн:	18,541,300,441.93	Нийт хөрөнгийн дүн:	33,957,389,082.25	Өр төлбөрийн нийт дүн:	22,294,624,890.31	Эздийн өмчийн дүн:	11,662,764,191.94	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:	33,957,389,082.25
Эргэлтийн хөрөнгийн дүн:	15,416,088,640.32												
Эргэлтийн бус хөрөнгийн дүн:	18,541,300,441.93												
Нийт хөрөнгийн дүн:	33,957,389,082.25												
Өр төлбөрийн нийт дүн:	22,294,624,890.31												
Эздийн өмчийн дүн:	11,662,764,191.94												
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:	33,957,389,082.25												

	Орлогын тайлан	Борлуулалтын орлого: 7,206,952,818.04 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: 5,406,101,132.94 Нийт ашиг: 1,800,851,685.10 Бусад орлого: 2,546,851.8 Борлуулалт, маркетингийн зардал: 131,569,150.24 Ерөнхий ба удирдлагын зардал: 1,597,512,947.71 Бусад зардал: 7,983,340.68 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) -24,261,907.63 Татвар төлөхийн өмнөх ашиг: 42,076,745.27 Орлогын татварын зардал: 6,804,456.19 Тайлант үеийн цэвэр ашиг: 35,272,289.08
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл: 6,473,162,300 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл: 11,727,544,902.86 2023 оны тайлант үеийн цэвэр ашиг: 35,272,289.08 2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл: 11,662,764,191.94
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн орлогын дүн: 6,628,951,406.15 Мөнгөн зарлагын дүн: 6,376,715,307 Үндсэн үйл ажиллагааны Мөнгөн гүйлгээ: 252,236,099.15 Мөнгөн орлогын дүн: 30,250,511.50 Мөнгөн зарлагын дүн: 227,121,534.45 Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн: -196,871,022.95 Мөнгөн орлогын дүн: 3,908,420,776.74 Мөнгөн зарлагын дүн: 3,962,207,868.77 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн: -53,787,092.03 Валютын хашийн зөрүү: -3,656,681.32 Цэвэр мөнгөн гүйлгээ: -2,078,697.15 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл: 24,992,984.77 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл: 22,914,287.62
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	<p>“Сэрэлт дөл аудит” ХХК нь “Булигаар” ХК-ийн (цаашид “Компани” гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн МУ-ын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.</p>	

1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.	
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд Ашигт ажиллагаа
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 0.26% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 0.3% Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/ Нийт активын өөрчлөлт 0.94 % Зээлийн багцын өөрчлөлт 0.81% Хөрөнгөд эзлэх хувь Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө 0.34% Өр төлбөр /Нийт хөрөнгө 0.65% Хөрвөх чадварын харьцаа Хөрвөх чадварын хөрөнгө/ 1.6% Татан төвлөрүүлсэн хөрөнгө
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Булигаар компанийн хувьд 2023 онд 60 мянга гаран үхрийн шир, 300 гаран мянган ямааны арьсыг хагас болон гүн боловсруулан дотоод гадаадын зах зээлд нийлүүлсэн байна. – Бүгд Найрамдах Итали Улс руу ямааны хагас боловсруулсан арьс экспортолж эхлэв. – Будгийн барабаны хүчин чадлыг нэмэгдүүлж, өдөрт 1000 өрөөл будаг хүчин чадал суурилуулав. – Агаарын гинжин хатаалгыг шинээр суурилуулж өдөрт 1000 өрөөл будаг хүчин чадал суурилуулав. – Хусах дамжлагын хүчин чадлыг нэмэгдүүлж 4 дэх хусах машиныг суурилуулав. – Монгол Улсад анх удаа Булигаар ХК Дэлхий арьс ширний зөвлөлийн (Leather Working Group - LWG) байгаль орчны менежментийн тогтолцооны аудитад тэнцэж, Монгол Улсын нэр албан ёсоор LWG-ийн бүрэлдэхүүнд багтав. Ирж буй 2024 ондоо хүний нөөцийн чадавхыг улам бүр сайжруулах чиглэлд анхаарч мэдлэг ур чадварт тулгуурласан бүтээлч хамт олны соёлыг цогцлоож салбарын тэргүүлэгч үйлдвэрүүд болохыг зорин ажиллаж байна.

2.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	2022.12.31-ний өдрийн байдлаар Капитрон банкнаас авсан зээлийн барьцаанд Ү-2206004461 тоот улсын бүртгэлийн дугаартай үл хөдлөх хөрөнгө болон Э-2206003772 дугаартай эзэмших эрхийг газрыг тус тус барьцаасан байгаа. Зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж байгаа болно.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.		
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
2023.04-2024.04 хүртэлх хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд 4.5 сая төгрөгийн цалинг олгох байгаа.		
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
<p style="text-align: center;">ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ</p> <p>Буиगाар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.</p> <p>2023 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ</p> <p>Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 14:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав.</p> <p>Хурлын ирц: Хуралд 88.16 хувийн саналын эрхтэй нийт 11 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан.</p> <p>Хурлаар танилцуулан хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр</p> <ul style="list-style-type: none"> - Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. - Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав. - Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Булигаар ХК-ийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “Хангалттай” гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав. 		

- Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулав.
- 2021 оны ногдол ашиг тараалтын тухай болон 2022 онд ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулж, 100%-ийн саналаар батлав.
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг танилцуулан, ТУЗ-ийн гишүүдийг 1 жилийн хугацаагаар сонгов.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллав.

Үүнд:

- *Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:* Жадамбын Эрдэнэбат, Төмөрбаатарын Болд, Чулуунбаатарын Нямдорж
- *Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:* Батчулууны Анхболд, Анхболдын Энхмэнд, Батчулууны Баянжаргал, Довжидын Гансүх, Бямбабаярын Баттүшиг, Цэрэндагвын Мөнхлхагва

“Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг батлан, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

2023.04.21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүн 1 жилийн хугацаатайгаар сонгогдсон бөгөөд 2024.04.19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал хэлэлцэгдэх болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ирц: ТУЗ-ийн дэргэд 3 хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 100 хувийн ирцтэйгээр 5 удаагийн хуралдаанаар 8 тогтоол, 5 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. ТУЗ-ийн хурлыг танхимаар, цахимаар, эчнээгээр зохион байгууллаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Цалин урамшууллын хороо: Тус хороо нь ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий ажилтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, компанийн хэмжээнд цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр хяналт, удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь ТУЗ-д туслахад оршино.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат
Гишүүд: ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Гансүх
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Баянжаргал
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Баттүшиг

Аудитын хороо: Тус хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн, дотоод хяналт, үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага хэрэгжилт, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар ТУЗ-ийг хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилласан.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Нямдорж
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Болд
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Анхболд

Нэр дэвшүүлэх хороо: компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах бодлого журмыг боловсруулах тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр хяналт, удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Болд
Гишүүд: ТУЗ-ийн дарга А.Энхмэнд
ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Мөнхлхагва

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:

Гүйцэтгэх захирал Б.Анхболд
Үйлдвэрлэл хариуцсан захирал Д.Гансүх
Ерөнхий нягтлан бодогч Г.Оюунгэрэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023 онд ТУЗ-ийн үйл ажиллагаанд 13,596,700 төгрөгийн зардлын төсөв (2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 02/23 тоот тогтоолоор батлагдсан.) төлөвлөж, гүйцэтгэл 10,266,350 төгрөг буюу 76 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Харин 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулах болно.

Зардлын төрөл	2023 он		2024 он
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
ТУЗ-ийн цалин урамшуулал	4,500,000	4,500,000	6,000,000
ХЭ-ийн хурлын зардал	2,021,700	1,702,100	2,121,700
Бусад зардал /Үйлчилгээний хураамж/	7,075,000	4,814,250	7,000,000
Нийт дүн	13,596,700	11,016,350	15,121,700

**ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮН**

1. Батчулуун АНХБОЛД

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1995	1996	Мэдээлэл зүйн магистр
2	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1990	1994	Худалдааны эдийн засагч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0730592	2016/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	Гүйцэтгэх захирал	2019 - одоо
2	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо
3	Дархан Минж ХХК	Ерөнхий захирал, Гүйцэтгэх захирал	2001 - 2018
4	Санком ҮЦК ХХК	Диллер	1998 - 2000
5	Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургууль	Мэдээлэл зүйн багш	1994 - 1996

2. Батчулуун БАЯНЖАРГАЛ

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1996	2000	Эдийн засагч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230359	2019/06	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо
2	Дархан Минж ХХК	Гүйцэтгэх захирал, дэд захирал	2006 - одоо
3	Монгол шуудан банк	Нягтлан бодогч	2000- 2006

3. Анхболд ЭНХМЭНД

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Вестминстерийн Их сургууль	ИБУИИНВУлс, Лондон хот	2013	2016	Хөрөнгө оруулалтын Санхүүч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230359	2019/06	Компанийн засаглал
2	Санхүүгийн зохицуулах хороо		2018	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Алтан Хоромсог ҮЦК ХХК	Гүйцэтгэх захирал	2022 - одоо
2	Мөнх Орших Капитал ББСБ	Гүйцэтгэх захирал	2021 -2022
3	Лугати ХХК	Гүйцэтгэх захирал	2020 -2021
4	Булигаар ХК	ТУЗ-ийн дарга	2019 - одоо
5	Екап ХХК	Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалт хариуцсан захирал	2018 - 2019
6	Монгол шир төсөл, Парк таун бонд	Санхүүгийн зөвлөх	2018
7	Ард секюритиз ҮЦК ХХК	Хөрөнгө оруулалтын аналит	2017
8	Монголын үнэт цаасны бирж ХХК	Төлбөр тооцооны ахлах ажилтан	2016 - 2017

4. Довжид ГАНСҮХ

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Барилгын Их Сургууль	ОХУ, Эрхүү хот	1986	1991	Барилгын технологич

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230360	2019/06	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо
2	Булигаар ХК	Үйлдвэрлэл хариуцсан захирал	2019 - одоо
3	Сүлд Ивээл Констракшн ХХК	Захирал	2014 - 2018
4	Дархан Минж ХХК	Үйлдвэрлэл хариуцсан захирал, Үйлдвэрлэлийн менежер	2004 - 2013

5. Бямбабаяр БАТТҮШИГ**Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
1	Ege University	БНТУ	2012	2016	Арьс шир боловсруулах инженер
2	СЭЗИС	Улаанбаатар	2016	2018	Санхүүгийн удирдлага

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн үндэсний төв		2023/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2023 - одоо
2	Булигаар ХК	Технологич	2019 - одоо
3	Монгол Шевро ХК	Технологич	2016 - 2019

6. Цэрэндагва МӨНХЛХАГВА**Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС, КтМСургууль	Улаанбаатар	2001	2005	Бизнесийн удирдлага
2	ШУТИС, КтМСургууль	Улаанбаатар	2006	2007	Хүний нөөцийн менежментээр магистр

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0131897	2022/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2022 - одоо
2	Булигаар ХК	Хүний нөөцийн ахлах менежер	2019 - одоо
3	ТМГрупп	Хүний нөөцийн зөвлөх	2016 - 2018
4	Алтайн хүдэр ХХК	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн	2008 - 2016
5	Гангар Инвест ХХК	Хүний нөөцийн менежер	2007 - 2008
6	МАТ ХХК	Менежер	2005 - 2006

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

7. Жадамба ЭРДЭНЭБАТ

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгсөн он	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС	Улаанбаатар	1987	1992	Математикч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0630111	2013/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	МУИС, ТИС	Багш	1992-1995
2	Ноёнсуудал брокерийн пүүс	Гүйцэтгэх захирал	1996 - 2001
3	Ханын материал ХК	Санхүү эрхэлсэн захирал	2002 - 2004
4	Хөдөө аж ахуйн бирж	Гүйцэтгэх захирал	2013 - 2016
5	Монголын Үнэт цаасны бирж	Гүйцэтгэх захирал	2017 – 2020
6	Эрдэс баялгийн бирж	Гүйцэтгэх захирал	2020 - 2022
7	Булигаар ХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022 - одоо
8	Тэргэл менежмент ХХК	Шинжээч ажилтан	2022 - одоо

8. Төмөрбаатар БОЛД

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгсөн он	Эзэмшсэн мэргэжил
1	ЗХУ Украин Машин байгууламжийн дээд	Луганск	1987	1992	Инженер

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0430482	2017/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Монголын хөрөнгийн бирж	Хяналтын ажилтан	1992-1995
2	Дэлгэрхангай брокерийн пүүс	брокер	1995 - хойш
3	Даац инвестмент ХХК	Гүйцэтгэх захирал	2017 – хойш
4	Булигаар ХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022 - одоо
	Монголын Үнэт цаасны бирж	ТУЗ-ийн ердийн гишүүн	2017 – одоо
	Тэлмэн групп ХХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2021 - одоо

9. Чулуунбаатар НЯМДОРЖ**Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгсөн он	Эзэмшсэн мэргэжил
1	ХААИС	Улаанбаатар	1988	1992	ХАА-н нягтлан бодогч эдийн засагч
2	МУИС	Улаанбаатар	1997	2000	Эрх зүйч
3	ХААИС	Улаанбаатар	2003	2003	Бизнесийн удирдлагын магистр

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0430968	2022/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	ШУА-ын харьяа ХАА-н Эдийн засгийн хүрээлэн	Эрдэм шинжилгээний ажилтан	1992 - 1993
2	Чингэлтэй дүүргийн Татварын алба	ТУБ	1993 - 1995
3	Төрийн хянан шалгах хороо, Нийслэлийн аудитын газар	Хянан байцаагч, ахлах хянан байцаагч, ахлах шинжээч	1995 -2014
4	Одбүртгэл аудит болон Мүүрь Аудит ХХК	Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан дэд захирал	2014 хойш
4	Булигаар ХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022 - одоо

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ КОДЕКС

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсан дагуу Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодексст нийцүүлэн дүрэм журмуудыг шинээр болон шинэчлэн баталж дуусгав.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Эхний улирлын байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ руу тус тус илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2023 оны 1-р улирлын санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайланг /маягт 2-ын дагуу/
- 2023 оны 2-р улирлын санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайланг /маягт 1-ын дагуу/
- 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал (161 хуудас материал, 1 ном)-ыг 2023.04.24-ний өдөр СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнасан.
- ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг www.mse.mn сайтад байршуулсан.


б. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Байхгүй.

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/				
	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 400,212,000 үүнээс 5 ба түүнээс дээш хувийг 3 хувьцаа эзэмшигч буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд:				
		<i>Нэр</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Хувь</i>	
		А.Энхмэнд	156,630,000	39.14%	
		Б.Анхболд	145,996,000	36.48%	
		Б.Баянжаргал	50,000,000	12.49%	
		Бусад 818 хувьцаа эзэмшигч	47,586,000	11.89%	
		Нийт дүн	400,212,000		
	Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно.				
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл				
	2023 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.				
9.	Ногдол ашгийн мэдээлэл				
	2022 оны ногдол ашиг тараалт				
	Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоолоо нэгж хувьцаанд 0.25 төгрөг хуваарилахаар шийдвэр гаргасан. Ногдол ашгийг 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож 2022 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгохоор ногдол ашиг зуучлуулан тараах гэрээний дагуу нийт 784 хувьцаа эзэмшигчийн дансанд 47,586,000 ширхэг хувьцаанд ногдох 11,896,500 төгрөгийг байршуулсан. 5-аас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу компаниас 3 хувьцаа эзэмшигчид ногдол ашигт ногдох мөнгийг олгосон.				
	<i>№</i>	<i>Ногдол ашиг тараах эрх бүхий байгууллага</i>	<i>Хувьцаа эзэмшигчдийн тоо</i>	<i>Хувьцааны тоо ширхэг</i>	<i>Албан татвар суутгагдсаны дараа олгосон мөнгөн дүн /төгрөгөөр/</i>
	1	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	784	47,586,000	11,896,500
	2	Булигаар ХК	3	352,626,000	88,156,500
		Нийт тараасан ногдол ашиг	787	400,212,000	100,053,000
					<i>/албан татвар суутгаагүй дүн/</i>
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл				
	LINEAPELLE 2023 /өвөл/				
	1. 2023 оны 2-р сарын 21-ний өдрөөс 23-ны өдрүүдэд Итали улсын Милан хотноо зохион байгуулагдсан арьс ширний салбарын томоохон үзэсгэлэн болох 99 удаагийн LINEAPELLE-д Монгол Улсаа төлөөлөн сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд анх удаа Булигаар компани нь амжилттай оролцлоо. Энэхүү үзэсгэлэнд оролцож, өөрсдийн үйлдвэрлэж буй үхрийн арьсыг танилцуулахын зэрэгцээ бизнес уулзалт, ажил хэргийн түншүүдтэй уулзалт хийх зорилготой билээ.				

Энэ удаагийн үзэсгэлэнд 950 гаруй оролцогч оролцон 13,000 зочид үзэсгэлэнг үзэж сонирхсон байна.

1981 онд нээлтээ хийж эхэлж байсан энэхүү үзэсгэлэн нь арьс шир, дагалдах хэрэгсэл, эд анги, гутлын нийлэг эдлэл, арьсан эдлэл, хувцас, тавилгын хамгийн өндөр зэрэглэлийн олон улсын үзэсгэлэн юм. LINEAPELLE нь намар, өвлийн үзэсгэлэн гэж жилд 2 удаа зохиогддог бөгөөд олон улсын бизнесийн үзэсгэлэнгийнхээ хувьд арьс шир, арьс ширэн эдлэлийн ирээдүйн трендийг тодорхойлох, олон улсын зах зээлийн хэлэлцүүлэг өрнүүлэх, бизнесийн сүлжээ байгуулах үндсэн боломж бололцоог үзэсгэлэнд оролцогчдод олгохыг чухалчилдаг.



СУРГАЛТ, ТУРШЛАГА СУДЛАХ

2. Германы улсын Worms хотод байрлах Trumpler компанид туршлага солилцохоор 2023 оны 2 дугаар сард 8 хүний бүрэлдэхүүнтэй манай технологичдын баг 10-14 хоногийн хугацаатайгаар гадаад томилолтоор ажиллалаа.

Trumpler компанийн лабораторид нэлээн олон төрлийн артикль дээр туршилтуудыг хийж лабораторийн технологич нартай гарсан үр дүн дээр санал сэтгэгдэл солилцлоо.

Түүнчлэн тус улсын арьс шир боловсруулах үйлдвэртэй танилцаж, тэдгээрийн удирдлага, технологич нартай уулзаж, тухайн улсын арьс шир боловсруулах үйлдвэрийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, өөрийн байгууллага дээр сайжруулалт хийхэд тус болохуйц мэдлэг, мэдээллийг олж авах, олж авсан мэдлэг, туршлагадаа тулгуурласан санал санаачилгуудыг хэлэлцэж, үйл ажиллагаандаа тусгаж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.



3. ХХААХҮЯ-аас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих” төслийн хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО) нь Итгэмжлэл, тохирлын үнэлгээний чадавхыг сайжруулах техник туслалцаа үзүүлж байгаа. Энэхүү техник туслалцааны хүрээнд 2023 оны 6-р сарын 11-17-ны өдрүүдэд ЮНИДО нь Монгол Улсын арьс ширний үйлдвэрлэлийн оролцогч талуудад зориулан Турк улсад туршлага судлах аялал зохион байгууллаа.

Тус аялалд арьс шир боловсруулах 6 үйлдвэр аж ахуйн нэгжийн удирдлагууд, технологичид, лаборатори, МАНУХолбоо, ХХААХҮЯ-ны холбогдох төлөөлөл бүхий нийт 16 хүн оролцов. Булигаар ХК-ийн зүгээс 3 ажилтан оролцсон. Туршлага судлах ажлын үр дүнд Турк улсын Тузла болон Бурса дахь LWG-ийн алтан медаль бүхий стандарт нэвтрүүлсэн арьс ширний үйлдвэрүүд, цэвэрлэх байгууламжууд, аж үйлдвэр технологийн паркууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лабораториудтай газар дээр нь очиж танилцсан.



LINEAPELLE 2023 /намар/


4. Итали улсын Милан хотноо зохион байгуулагдсан Lineapelle 2023 дэлхийн арьс, ширний үзэсгэлэнд 2 дахь жилдээ амжилттай оролцлоо. Тус үзэсгэлэнд оролцсоноор Монголын арьс, ширэн бүтээгдэхүүнийг дэлхийд таниулах, худалдааны цар хүрээг өргөсгөх, бүтээгдэхүүний чанар, технологийн нэмэгдүүлэх гэх мэт олон зорилготой. 1981 онд нээлтээ хийж байсан эхэлж байсан энэхүү үзэсгэлэн нь арьс шир, дагалдах хэрэгсэл, эд анги, гутлын нийлэг эдлэл, арьсан эдлэл, хувцас, тавилгын хамгийн өндөр зэрэглэлийн олон улсын үзэсгэлэн юм. Бид энэ жилийн хувь тус үзэсгэлэнд зөвхөн арьс, ширнээс гадна, монгол улсад хийсэн гутал, цүнх болон дэвшилтэд технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ танилцуулснаараа өмнө жилээс илүү өргөн цар хүрээг хамарсан.



ШАНХАЙН ҮЗЭСГЭЛЭН

5. Үзэсгэлэн худалдаа нь бизнесийн харилцаа холбоог бий болгох хамгийн тохиромжтой платформ бөгөөд Дижитал маркетингаас ялгаатай нь үзэсгэлэн зорилгот бүлэгтэйгээ нүүр тулан харилцах, урт хугацааны бизнес харилцаа тогтоох боломжийг олгодог билээ.

Булигаар ХК-ийн техник, технологи болон удирдлагын багынхан Хятад улсын Шанхай хотод зохион байгуулагдсан арьс, ширний үзэсгэлэнд оролцож тоног төхөөрөмж, технологийн талаар үзэж танилцан олж авсан мэдлэг, туршлагаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахыг зорьж байна.



ОЛОН УЛСЫН “LWG” СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДАН АВЛАА.

Монгол Улсад анх удаа “Булигаар” ХК Дэлхийн арьс ширний зөвлөлийн (Leather Working Group - LWG) байгаль орчны менежментийн тогтолцооны аудитад тэнцэж, Монгол Улсын нэр албан ёсоор LWG -ийн бүрэлдэхүүнд багтав.

НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО) нь Арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд LWG олон улсын стандарт нэвтрүүлэхээр зорин ажиллаж байгаа. Энэхүү ажлын хүрээнд ЮНИДО-ын зөвлөхүүд, МАШҮХ-той хамтран үйлдвэрүүдэд газар дээр нь зөвлөгөө өгөх, LWG болон ISO14001 байгаль орчны менежментийн тогтолцооны сургалтуудыг зохион байгуулсан. Тус стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлснээр Монгол Улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарын нэр хүнд дэлхийн түвшинд дээшилж аж ахуйн нэгжүүд хэрэглэгчийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн экспортын хэмжээгээ нэмэгдүүлэх зэрэг олон боломжууд бий болно.

“Булигаар” ХК нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүнийг хүргэх зорилгоор 2023 оны 1 дүгээр улирлаас эхлүүлэн үйл ажиллагаандаа олон улсын LWG стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байсан билээ. Бид 2023 оноос эхлэн LWG хэрэгжүүлэх төслийн багийг байгуулан стандартыг үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан ба 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Олон улсын “Leather Working Group”-аас “Булигаар” ХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, тохирлын үнэлгээ, хяналт шинжилгээгээр олон улсын LWG стандартын шаардлагыг бүрэн хангасан тул ийнхүү баталгаажуулалтын гэрчилгээг гардууллаа.

Олон улсын LWG стандарт нь арьс шир үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын үйл явцыг байгаль орчин, химийн бодисын менежмент, ханган нийлүүлэлт, зохистой хэрэглээ, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаа, нийгмийн хариуцлага зэрэг асуудлуудтай холбоотойгоор үнэлэх зорилго бүхий байгаль орчны олон улсын аудит юм.

Дэлхий нийтээрээ хэрэглэгчдийн чиг хандлага эко үзэл баримтлал руу чиглэж байгаа тул дэлхий нийтээрээ болон томоохон брэнд хувцас, гутал үйлдвэрлэгчид зөвхөн LWG стандартын гэрчилгээтэй арьсаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон.



Certificate

Facility Name	Buligaar JSC
Facility Address	Tannery Industrial Zone, Chinggis Khan Avenue, 20th Khoroo, Khan-Uul District, 17031, Ulaabaatar, Mongolia
Unique Ref. No.	BUL101
Has been audited against the requirements of the LWG Leather Manufacturer Audit Standard. Version 7.2.2	
Category	C - Raw hide/skin to finished leather
Rating	Audited
Audit Reference	BUL101
Date of Audit	20 November 2023
Date of Expiry	20 November 2025
Auditor	Aga Walkiewicz



EKOTORO SP. Z O.O. (TAX ID: 947-263-59-47)
1905 Roku 21/101, Radom, 26-600, Poland
aga@ekotoro.com, +48 796 520 220



Scan to validate

6. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил тутам хамруулдаг. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны 4-р сард Эрхэт манал увидас эмнэлэгтэй хамтран 60 гаруй ажилтныг үзлэг шинжилгээнд хамруулсан. 2024 онд үзлэгт хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Анхболд
Албан тушаал: “Булигаар” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Овог, нэр: Д.Алтантөгс
Албан тушаал: “Сэрэлт дөл аудит” ХХК аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Оюунгэрэл
Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

Овог, нэр: Ц.Мөнхлхагва
Албан тушаал: ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг: